



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ХӨА-2022/187/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Хөвсгөл аймаг  
2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар  
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatar@audit.gov.mn  
Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ  
Утас: 88090438 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn  
Аудитор: С.Гансүх  
Утас: 95908400 Цахим хаяг: gansukhsa@audit.gov.mn  
Төгс суурь стандарт Аудит ХХК-ийн  
Ерөнхий захирал: Т.Батсайхан  
Утас: 99010760 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com  
Аудитын менежер: Г.Оюунгэрэл  
Утас: 77551229 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com  
Ахлах аудитор: О.Хосбаяр  
Утас: 77551229 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

1. Аудитын санал дүгнэлт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал .....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт .....	17
4.1 Залруулсан алдаа .....	17
4.2 Төлбөрийн акт .....	17
4.3 Албан шаардлага .....	17
4.4 Зөвлөмж.....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	19

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2022.02.25 № 01/775  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЭРДЭНЭБУЛГАН  
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН  
ДАРГА Б.ЛХАГВАСҮРЭН ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон		/төгрөгөөр/	
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>57,378,565.86</b>	<b>141,516,897.68</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>700,000.00</b>	<b>56,251,900.00</b>
33300	Татаас, санхүүжилтийн авлага	700,000.00	00.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	<b>00.00</b>	<b>56,251,900.00</b>
3351	Байгууллагаас авах авлага	00.00	56,251,900.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>56,678,565.86</b>	<b>85,264,997.68</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>18,928,409.32</b>	<b>44,038,386.65</b>
35110	Тусгай зориулалттай материал	9,178,192.00	14,510,470.00
35130	Эм боох материал	9,750,217.32	29,527,916.65
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>37,750,156.54</b>	<b>41,226,611.03</b>
35410	Бичиг хэргийн материал	1,651,914.00	1,321,388.00
35420	Аж ахуйн материал	17,371,383.00	17,791,990.00
35440	Түлш, шатах тослох материал	4,210,720.00	8,285,362.00
35450	Барилгын засварын материал	1,822,000.00	1,822,000.00
35460	Хүнсний материал	4,278,584.55	3,554,391.03
35470	Бусад хангамжийн материал	8,415,554.99	8,451,480.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>210,428,263.77</b>	<b>273,539,669.55</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>210,428,263.77</b>	<b>273,539,669.55</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>177,001,555.47</b>	<b>247,481,711.29</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	138,010,620.00	138,010,620.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-40,777,336.48	-58,642,504.72
39203	Авто-тээврийн хэрэгсэл	39,260,000.00	59,250,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-14,224,166.67	-21,564,166.71
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	77,605,760.00	97,937,219.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-53,556,752.91	-11,927,608.14
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	41,515,602.00	39,556,772.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-10,832,170.47	-12,413,620.14
39214	Бусад үндсэн хөрөнгө	9,078,379.00	17,650,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-9,078,379.00	-375,000.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>33,426,708.30</b>	<b>26,057,958.26</b>
39301	Програм хангамж	15,825,000.00	475,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-8,107,291.70	-126,041.74
39303	Бусад биет бус хөрөнгө	25,709,000.00	25,709,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>267,806,829.63</b>	<b>415,056,567.23</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>267,806,829.63</b>	<b>415,056,567.23</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>267,806,829.63</b>	<b>415,056,567.23</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	195,317,795.00	195,317,795.00
51101	Өмч: - төрийн	195,317,795.00	195,317,795.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>-61,179,875.05</b>	<b>89,134,366.23</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-61,179,875.05	-58,115,371.37
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	147,249,737.60
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	133,668,909.68	130,604,406.00
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>267,806,829.63</b>	<b>415,056,567.23</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон		/төгрөгөөр/	
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>488,210,118.00</b>	<b>1,009,363,120.56</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>474,226,448.00</b>	<b>302,233,490.56</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>66,958,808.00</b>	<b>302,233,490.56</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	66,958,808.00	302,233,490.56
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	66,958,808.00	302,233,490.56
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	<b>49,463,740.00</b>	<b>00.00</b>
122001	Хандив тусламж /дотоод/	30,213,740.00	00.00
<b>123</b>	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	<b>357,803,900.00</b>	<b>00.00</b>
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	357,803,900.00	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>13,983,670.00</b>	<b>297,880,130.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	00.00	409,249,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>13,983,670.00</b>	<b>255,923,300.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,983,670.00	199,671,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	56,251,900.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>00.00</b>	<b>22,000,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	22,000,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>00.00</b>	<b>19,956,830.00</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	00.00	19,956,830.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>455,124,512.58</b>	<b>854,613,382.96</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>455,124,512.58</b>	<b>854,613,382.96</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>454,924,512.58</b>	<b>797,821,382.96</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>273,815,000.00</b>	<b>357,374,055.00</b>
210101	Үндсэн цалин	190,376,600.00	190,016,600.00
210102	Нэмэгдэл	66,178,000.00	111,469,600.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	4,415,855.00
210104	Урамшуулал	17,260,400.00	16,230,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	35,242,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>36,929,870.00</b>	<b>48,009,300.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	25,914,610.00	33,663,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,684,295.00	3,585,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	580,595.00	716,680.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,478,280.00	7,168,900.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>14,372,687.01</b>	<b>10,479,108.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,460,780.00	853,658.00
210302	Түлш, халаалт	11,911,907.01	9,625,450.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>24,567,315.01</b>	<b>47,050,358.99</b>
210401	Бичиг хэрэг	3,015,545.00	3,357,112.00
210402	Тээвэр, шатахуун	16,020,650.00	26,116,850.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,900,000.00	2,371,742.00
210404	Ном, хэвлэл	64,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	1,857,640.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,567,120.01	4,798,209.99
210408	Бараа материал акталсны зардал	00.00	8,548,805.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>43,190,328.92</b>	<b>267,589,211.75</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	37,101,993.32	257,968,234.23
210502	Хоол, хүнс	5,529,435.60	8,534,977.52
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	558,900.00	1,086,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,574,460.00</b>	<b>6,458,800.00</b>
210604	Урсгал засвар	1,574,460.00	6,458,800.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,500,000.00</b>	<b>1,500,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,500,000.00	1,500,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>23,527,800.00</b>	<b>15,354,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,985,400.00	14,321,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	850,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	65,400.00	96,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	38,000.00	48,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	19,000.00	19,000.00
210807	Газрын төлбөр	20,000.00	20,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>35,447,051.64</b>	<b>44,006,549.22</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,133,500.00	4,188,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	30,313,551.64	39,818,049.22
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>200,000.00</b>	<b>56,792,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>200,000.00</b>	<b>56,792,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	56,792,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>33,085,605.42</b>	<b>154,749,737.60</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>00.00</b>	<b>7,500,000.00</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	7,500,000.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>00.00</b>	<b>-7,500,000.00</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>33,085,605.42</b>	<b>147,249,737.60</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>C08</b>	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>195,317,795.00</b>	<b>-61,179,875.05</b>	<b>267,806,829.63</b>
<b>D01</b>	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>195,317,795.00</b>	<b>-61,179,875.05</b>	<b>267,806,829.63</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	3,064,503.68	3,064,503.68
<b>D03</b>	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>195,317,795.00</b>	<b>-58,115,371.37</b>	<b>270,871,333.31</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	-3,064,503.68
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	147,249,737.60	147,249,737.60
<b>D09</b>	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>195,317,795.00</b>	<b>89,134,366.23</b>	<b>415,056,567.23</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон		/төгрөгөөр/	
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>421,251,310.00</b>	<b>651,577,730.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>407,267,640.00</b>	<b>00.00</b>
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	<b>49,463,740.00</b>	<b>00.00</b>
122001	Хандив тусламж /дотоод/	30,213,740.00	00.00
<b>123</b>	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	<b>357,803,900.00</b>	<b>00.00</b>
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	357,803,900.00	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>13,983,670.00</b>	<b>651,577,730.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	00.00	409,249,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>13,983,670.00</b>	<b>200,371,400.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,983,670.00	200,371,400.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>00.00</b>	<b>22,000,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	22,000,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>00.00</b>	<b>19,956,830.00</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	00.00	19,956,830.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>413,951,330.00</b>	<b>621,002,665.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>413,951,330.00</b>	<b>621,002,665.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>413,751,330.00</b>	<b>564,210,665.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>273,815,000.00</b>	<b>357,374,055.00</b>
210101	Үндсэн цалин	190,376,600.00	190,016,600.00
210102	Нэмэгдэл	66,178,000.00	111,469,600.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	4,415,855.00
210104	Урамшуулал	17,260,400.00	16,230,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	35,242,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>36,929,870.00</b>	<b>48,009,300.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	25,914,610.00	33,663,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,684,295.00	3,585,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,272,090.00	2,875,020.00
210204	Ажилгүйдлийн даатгал	580,595.00	716,680.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,478,280.00	7,168,900.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>17,250,000.00</b>	<b>16,214,935.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,460,780.00	853,658.00
210302	Түлш, халаалт	14,259,220.00	15,145,342.00
210303	Цэвэр, бохир ус	530,000.00	215,935.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>24,214,420.00</b>	<b>41,695,168.00</b>
210401	Бичиг хэрэг	1,500,000.00	1,496,386.00
210402	Тээвэр, шатахуун	13,984,400.00	24,671,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,900,000.00	2,571,942.00
210404	Ном, хэвлэл	330,000.00	330,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000,000.00	2,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,500,020.00	10,625,240.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>25,969,240.00</b>	<b>73,674,707.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	13,379,240.00	61,148,923.00
210502	Хоол, хүнс	7,050,000.00	7,525,784.00

**Эрдэнэбулган сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,540,000.00	5,000,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,400,000.00</b>	<b>5,200,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	130,000.00	1,130,000.00
210602	Тавилга	2,270,000.00	570,000.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	3,500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,500,000.00</b>	<b>1,500,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,500,000.00	1,500,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>24,527,800.00</b>	<b>16,354,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,985,400.00	14,321,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	850,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	65,400.00	96,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	38,000.00	48,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	19,000.00	19,000.00
210807	Газрын төлбөр	20,000.00	20,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,000,000.00	1,000,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>5,145,000.00</b>	<b>4,188,500.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,145,000.00	4,188,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>200,000.00</b>	<b>56,792,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>200,000.00</b>	<b>56,792,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	56,792,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>7,299,980.00</b>	<b>30,575,065.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>6,599,980.00</b>	<b>30,575,065.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>6,599,980.00</b>	<b>30,575,065.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>6,599,980.00</b>	<b>30,575,065.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,599,980.00	30,575,065.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-6,599,980.00</b>	<b>-30,575,065.00</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>700,000.00</b>	<b>-</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон		/төгрөгөөр/			
Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	461,273,600.0	451,206,330.0	10,067,270.0	97.8
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	461,273,600.0	451,206,330.0	10,067,270.0	97.8
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	461,273,600.0	451,206,330.0	10,067,270.0	97.8
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	316,858,000.0	313,867,055.0	2,990,945.0	99.1
210101	Үндсэн цалин	186,459,200.0	186,459,200.0	00.0	100.0
210102	Нэмэгдэл	71,520,000.0	71,520,000.0	00.0	100.0

**Эрдэнэбулган сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,596,800.0	4,415,855.0	1,180,945.0	78.9
210104	Урамшуулал	18,040,000.0	16,230,000.0	1,810,000.0	90.0
210105	Гэрээт ажлын хөлс	35,242,000.0	35,242,000.0	00.0	100.0
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	42,775,900.0	42,531,600.0	244,300.0	99.4
210201	Тэтгэврийн даатгал	30,101,600.0	29,929,700.0	171,900.0	99.4
210202	Тэтгэмжийн даатгал	3,168,600.0	3,150,500.0	18,100.0	99.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,534,800.0	2,520,400.0	14,400.0	99.4
210204	Ажилгүйдлийн даатгал	633,700.0	630,000.0	3,700.0	99.4
210205	Эрүүл мэндийн даатгал	6,337,200.0	6,301,000.0	36,200.0	99.4
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	18,500,000.0	18,500,000.0	00.0	100.0
210301	Гэрэл, цахилгаан	3,500,000.0	853,658.0	2,646,342.0	24.4
210302	Түлш, халаалт	12,500,000.0	15,145,342.0	-2,645,342.0	121.2
210303	Цэвэр, бохир ус	2,500,000.0	2,501,000.0	-1,000.0	100.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	27,157,000.0	26,616,968.0	540,032.0	98.0
210401	Бичиг хэрэг	1,500,000.0	1,496,386.0	3,614.0	99.8
210402	Тээвэр, шатахуун	18,277,000.0	18,277,000.0	00.0	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,050,000.0	2,571,942.0	478,058.0	84.3
210404	Ном, хэвлэл	330,000.0	330,000.0	00.0	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000,000.0	2,000,000.0	00.0	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,000,000.0	1,941,640.0	58,360.0	97.1
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	30,565,700.0	28,469,207.0	2,096,493.0	93.1
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	19,265,700.0	17,528,423.0	1,737,277.0	91.0
210502	Хоол, хүнс	6,300,000.0	5,940,784.0	359,216.0	94.3
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,000,000.0	5,000,000.0	00.0	100.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	14,500,000.0	13,500,000.0	1,000,000.0	93.1
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,000,000.0	6,000,000.0	00.0	100.0
210602	Тавилга	4,000,000.0	4,000,000.0	00.0	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,000,000.0	00.0	1,000,000.0	00.0
210604	Урсгал засвар	3,500,000.0	3,500,000.0	00.0	100.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,500,000.0	1,500,000.0	00.0	100.0
210702	Дотоод албан томилолт	1,500,000.0	1,500,000.0	00.0	100.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,033,000.0	2,033,000.0	00.0	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	850,000.0	850,000.0	00.0	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	96,000.0	96,000.0	00.0	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	48,000.0	48,000.0	00.0	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	19,000.0	19,000.0	00.0	100.0
210807	Газрын төлбөр	20,000.0	20,000.0	00.0	100.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,000,000.0	1,000,000.0	00.0	100.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	7,384,000.0	4,188,500.0	3,195,500.0	56.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,384,000.0	4,188,500.0	3,195,500.0	56.7
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	461,273,600.0	451,206,330.0	10,067,270.0	97.8
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	409,249,500.0	409,249,500.0	00.0	100.0

131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	409,249,500.0	409,249,500.0	00.0	100.0
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	22,000,000.0	22,000,000.0	00.0	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	22,000,000.0	22,000,000.0	00.0	100.0
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	30,024,100.0	19,956,830.0	10,067,270.0	66.5
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	30,024,100.0	19,956,830.0	10,067,270.0	66.5
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	25.00	25.00	00.0	100.0
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	00.0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	16.00	16.00	00.0	100.0
620003	Үйлчлэх ажилтан	08.00	08.00	00.0	100.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгсгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>200,371,400.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>200,371,400.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>143,579,400.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>43,507,000.00</b>
210101	Үндсэн цалин	3,557,400.00
210102	Нэмэгдэл	39,949,600.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>5,477,700.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	3,733,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	435,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	354,620.00
210204	Ажилгүйдлийн даатгал	86,680.00
210205	Эрүүл мэндийн даатгал	867,900.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>35,068,200.00</b>
210402	Тээвэр, шатахуун	6,394,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	28,673,600.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>45,205,500.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	43,620,500.00
210502	Хоол, хүнс	1,585,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>14,321,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,321,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>56,792,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>56,792,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	56,792,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>200,371,400.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>200,371,400.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	200,371,400.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>00.00</b>
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Эрдэнэбулган сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг Ахлах аудитор О.Хосбаяр, аудитор Г.Мөнхбаяр нар гүйцэтгэж, чанарын хяналтыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Гансүх, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ, аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар, Төгс суурь стандарт аудит ХХК-ийн чанарын хяналтын менежер Г.Оюунгэрэл, гүйцэтгэх захирал Т.Батсайхан нар хэрэгжүүлж, аудитын тайланг 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн дотор шалгагдагч байгууллагын удирдлагад гардуулна.

Эрдэнэбулган сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төгс суурь стандарт аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 02 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын эрүүл мэндийн төвийн 2021 онд Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүн амын эрэлт хэрэгцээнд нийцсэн, чанар аюулгүй байдлыг хангасан, ил тод хүртээмжтэй үзүүлэх, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд тулгуурлан, ард иргэдэд эрүүл зөв амьдрах дадал үйлийг оновчтой тэгш хүртээмжтэйгээр хүргэж, орон нутгийн иргэдийн дундаж наслалт, амьдралын чадамжийг уртасгах, халдварын эрсдэлийг багасган, хүн амын өвчлөл эндэгдлийг бууруулж ажиллах зорилго тавьсан байна.

Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ, эх барихын тусламж, үйлчилгээ, сувилахуйн болон сэргээн засахын дагнасан тусламж, үйлчилгээ шаардлагатай иргэнийг холбогдох эрүүл мэндийн байгууллагад илгээх, эргэх холбоо тогтоох, тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах
- Харьяа нутаг дэвсгэрийн хүн амын дунд нийгмийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах хөтөлбөр, арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжүүлэх
- Сэргээн засах, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ, өдрийн эмчилгээ, оношилгоо, шинжилгээ хийх
- Сум, тосгоны эрүүл мэндийн төв түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- “Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан” 2021 оны 04 сарын 30-ны 67/A/268 дугаар тушаалаар Коронавируст халдвар (Ковид-19)-ын эсрэг эрүүл мэндийн цогц тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх журам, тусламж үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ батлах тухай
- “Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан” 2021 оны А/387/99 журамд нэмэлт оруулах, төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах тухай
- “Хөвсгөл аймгийн засаг даргын захирамж” 2021 оны А243 түр журам батлах тухай. Коронавируст халдвар (Ковид-19)-ыг илрүүлэх шинжилгээг төлбөртэй хийх түр журмаар баталсан байна.
- Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйл. “Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ болох "12.7" хувьд өөрчлөлт орж "11.7" хувь, Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ болох "12.5" хувьд өөрчлөлт орж "11.5" хувь болж өөрчлөгдсөн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн ба байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналтын нэгжийг шинэчлэн томилох тухай 2021 оны 03 сарын 10 өдрийн А/14 тушаалаар бүрэлдэхүүнийг шинэчилж 10 чиглэлээр ажлын төлөвлөгөөг баталж биелэлт нь 90 хувьтай байна.

Дотоод хяналтын баг нь үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө гарган, улиралд нэг удаа хяналт хийж, тайланг удирдлагын багт танилцуулж шийдвэрлүүлдэг ба төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлагналыг баримтжуулсан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрдэнэбулган сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн нийт зардал 854.6 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 12.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80-хувиар буюу 10.2 сая төгрөгөөр тогтоосон.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Эрдэнэбулган сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 147.3 сая төгрөгөөр буюу 55.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн үлдэгдлийг харуулав.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	0.7	56.3	55.6
Бараа материал	56.7	85.3	28.6
Биет хөрөнгө	177.0	247.5	70.5
Биет бус хөрөнгө	33.4	26.4	-7.3
<b>Нийт хөрөнгө</b>	<b>267.8</b>	<b>415.1</b>	<b>147.3</b>
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>267.8</b>	<b>415.1</b>	<b>147.3</b>

Авлагын үлдэгдэл 56.3 сая төгрөг байгаа нь эрүүл мэндийн даатгалын сангаас ковид цар тахлын үед иргэдэд үзүүлсэн цогц тусламж үйлчилгээний санхүүжилтийн авлага. Энэ авлагын тооцоог нийлж баталгаажуулсан.

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 28.6 сая төгрөгөөр өсөж 85.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Материаллаг нөлөөтэй бараа материал:

- Улсын төсвийн хөрөнгөөр худалдан авсан эм боох материал 61.5 сая,
- Эрүүл мэндийн газраас эрх шилжүүлэн авсан вакцин, эм тариа 214.5 сая
- улсын төсвийн хөрөнгөөр худалдан авсан түлш, шатах тослох материал 39.8 сая,
- Хүнсний материал 6.9 сая төгрөг,
- Эрүүл мэндийн сайдын 2021 оны 12 сарын 07 өдрийн А/149 тоот тушаалаар “Монпэн” төслийн хүрээнд эмнэлгийн хэрэгсэл 6.1 сая төгрөг,
- ХӨСҮТ -ээс эрх шилжүүлсэн эмнэлгийн хэрэгсэл 0.7 сая төгрөг,
- Эрүүл мэндийн сайдын 2021 оны 12 сарын 07 өдрийн А/149 тоот тушаалаар “Монпэн” төслийн хүрээнд эмнэлгийн хэрэгсэл 0.6 сая төгрөг,
- УИХ-ын гишүүний багцаас 0.3 сая төгрөгийн мананцар үүсгэгч,
- Иргэний хандиваар 0.3 сая төгрөгийн хүнсний материал,
- Бусад хангамжийн материал 32.7 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн бол
- Тайлант хугацаанд нийт 326.8 сая төгрөгийн бараа материал зарцуулсан байна.

Биет хөрөнгийн үлдэгдэл 70.5 сая төгрөгөөр өсөж 247.5 сая төгрөг болсон. Үүнд материаллаг нөлөөтэй биет хөрөнгө:

- Иргэний хандиваар авсан зөөврийн компьютер 2 ширхэг 2.4 сая төгрөг,

- Эрүүл мэндийн сайдын 2021 оны 12 сарын 01 өдрийн А/741 тоот тушаалаар “Монпэн” төслийн хүрээнд суурин компьютер, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил нийт 4.1 сая төгрөг,
- Орон нутгийн өмчийн газрын даргын 2021 оны 07 сарын 27 өдрийн А/90 тушаалаар зөөврийн технологи, тоног төхөөрөмж 10.9 сая,
- Орон нутгийн өмчийн газрын 2021 оны 11 сарын 15-ны өдрийн А/16 тушаалаар лабораторийн тоног төхөөрөмж 14.2 сая төгрөг,
- Сумын ИТХ-ын 2021 оны 12 сарын 18-ны өдрийн 02-р тогтоолоор орон нутгийн хөгжлийн сангаас 15.0 сая төгрөгийн гүний худаг,
- ХӨСҮТ-ээс вакцины хөргөгч 4.8 сая,
- УИХ-гишүүний багцаас хүчилтөрөгчийн аппарат 2.6 сая,
- Эрүүл мэндийн газрын даргын 2021 оны 12 сарын 7-ны өдрийн А/148 -р тушаалаар 2D аппарат 6.7 сая,
- Эрүүл мэндийн даатгалын сангийн ковидын цогц үйлчилгээний санхүүжилтээс суудлын автомашин Toyota Probox 4wd,/ улсын дугаар 69-70 ХӨҮ /-ыг 19,990,000 төгрөгөөр худалдан авсан байна. Эрдэнэбулган сумын онцгой комиссын 2021 оны 12 сарын 20-ны өдрийн 02 тоот тогтоолоор суудлын авто машин авахыг зөвшөөрсөн, хөрөнгө зарцуулах тухай ЭМТ-ийн даргын 2021 оны 12 сарын 22-ны өдрийн А/57 тушаалаар худалдан авах шийдвэр тус тус гаргасан байна. Худалдан авалтыг шууд худалдан авалтаар УБ хотын УАЗ МЕГА ХХК -аас 19,990,000 төгрөгөөр авсан. Худалдах, худалдан авах ШХА No 21/44 тоот гэрээг 2021 оны 12 сарын 24-ний өдөр байгуулсан, гэрээнд хүн эмнэлгийн талаас жолооч Б. Мөнхбат гарын үсэг зурж захирал Лхагвасүрэн баталсан байна.
- Аймгийн ИТХ-ын 2021 оны 12 сарын 20-ны өдрийн 111 тоот тогтоолоор 27.9 сая төгрөгийн машин тоног төхөөрөмжийг данснаас хасаж 13.7 сая төгрөгөөр дахин үнэлж орлогод авсан. Мөн шийдвэрээр 1.2 сая төгрөгийн хөрөнгийн тавилга эд хогшлыг данснаас хасаж дахин үнэлж 0.7 сая төгрөгөөр орлогод авсан. Бусад үндсэн хөрөнгө 8.6 сая төгрөгийг данснаас хасаж 2.6 сая төгрөгөөр үнэлж орлогод авсан.
- Биет бус хөрөнгө буурсан гол шалтгаан нь Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 сарын 20-ны 109 тоот тогтоолоор 50 хувийн элэгдэл байгуулсан “Цахим эрүүл мэнд” программ хангамжийг 7.5 сая төгрөгийн алдагдалтай үнээр данснаас хассан байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 461.3 сая төгрөгөөр, нийт зарлагыг 461.3 сая төгрөгөөр тус тус тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсөв захирагч 2021 оны төсвийг 461.3 сая төгрөгөөр баталсан байна. Үүнд:

- Улсын төсвөөс 409.3 сая төгрөг,
- орон нутгийн төсвөөс 22.0 сая төгрөг,

- эрүүл мэндийн даатгалын сангаас 30.0 сая төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөсөн.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх “Эмнэлгийн тусламж үйлчилгээ” хөтөлбөрийг нийт 461.3 сая төгрөгөөр хэрэгжүүлсэн.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тухайн байгууллагад дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид нийт 200.4 сая төгрөг хуваарилснаас эрүүл мэндийн даатгалын сангаас 163.6, Эрүүл мэндийн газраас 36 сая төгрөг, бусад санхүүжилт 0,8 сая төгрөгийг тус тус авсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүссэн болон аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй онцолсон бусад асуудал, үйл ажиллагааг харуулбал. Үүнд:

- Корона вирус -2019 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэхэд байгууллагын тасралтгүй үйл ажиллагааг хангасан.
- Ковидын тархалттай холбогдсон эрүүл мэндийн тусламж үйлчилгээ ихээхэн нэмэгдсэн. Ковидоор 374 хүн өвчилж эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан, дархлаажуулалтаар 4473 тун вакцинд иргэдийг хамруулж нийт 219,9 төгрөг нэхэмжилснээс 163,6 сая төгрөгийн санхүүжилт авч 56,3 сая төгрөгийн авлагатай гарсан байна.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл болох гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан, худалдан авах ажиллагааны тайлан нь санхүүгийн бус мэдээллийг агуулсан тул санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

Аудитаар материаллаг буруу тайлагналын болон нөлөө бүхий эрсдэл байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгөөр Toyota Probox 4wd суудлын автомашин 20.0 сая төгрөгөөр худалдан авч ТЕЗ-ийн шийдвэргүйгээр урсгал төсвийг хөрөнгийн төсөвт шилжүүлэн, зориулалт бусаар зарцуулсан байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийг авч үзэхэд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээлбэл зохих 461,3 сая төгрөгийн 73 мэдээллээс 460.0 сая төгрөгийн 70 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж 1.3 сая төгрөгийн 3 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шалгахад:

- 2021 оны эрүүл мэндийн даатгалын сангийн урсгал төсвийн санхүүжилтээс ТЕЗ-ийн шийдвэргүйгээр суудлын авто машин 20.0 сая төгрөгөөр худалдан авч “Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан төсвийн шууд захирагч, түүний бүрэн эрх, мөн хуулийн 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн.
- Шилэн дансанд байршуулах мэдээлэлд аудитын тайланг хугацаа хоцроож байршуулсан нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Эрүүл мэндийн яамны сайдын 2019 оны А/540 дугаар тушаалаар сумдын хүн эмнэлгийг эрүүл мэндийн төв болгон өөрчилж тус тушаалаар өмнөх тушаалууд хүчингүй болсон байна. Үүнд: Эрүүл мэндийн сайдын Сум дундын эмнэлэг байгуулах тухай 2003 оны 114, Сумдын эмнэлгийн статусыг өөрчлөх тухай 2011 оны 292, Сум дундын эмнэлэг байгуулах тухай 2013 оны 256 дугаар тушаалыг тус тус хүчин болгосон.

Үүнтэй холбогдуулан ЭМЯ-ны сайдын А/540 тушаалаар сумын эрүүл мэндийн төвийн зэрэглэл, бусад сумын хүн амын хамруулан тусламж, үйлчилгээ үзүүлэх зарим сумын эрүүл мэндийн төвийн үйлчлэх хүрээг тогтоох, багийн эмчийн салбар байгуулах, өөрчлөн зохион байгуулах журам гарсантай холбогдуулан сумдын хүн эмнэлгийг эрүүл мэндийн төв болгон өөрчилсөн байна. Улсын бүртгэлийн гэрчилгээ дээр Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын хүн эмнэлэг нэртэйгээр үйл ажиллагааг явуулж байгаа нь Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/540 дугаар тушаалтай зөрчилдөж байна.

#### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх санхүүгийн тайланд Ихэр мөрөн аудит ХХК аудит хийж 3 зөвлөмж хүргүүлсний 2 зөвлөмж бүрэн биелж, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт дутуу байна.

#### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Эрүүл мэндийн яамны сайдын 2019 оны А/540 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж Улсын бүртгэлийн гэрчилгээ дээрх оноосон нэрийг өөрчилсөн байх.

- Аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсээс ковид цар тахлын үед иргэдэд үзүүлсэн цогц тусламж үйлчилгээнээс авах авлага 56,3 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан асуудлыг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

---

Аудитаар нийт 0.7 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн алдаа илэрснийг аудитын хугацаанд залруулсан болно.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 0.7 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн алдаа илэрснийг аудитын хугацаанд залруулсан болно.

### 4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй.

### 4.3 Албан шаардлага

#### 1.1. Илрүүлэлт:

2021 оны эрүүл мэндийн даатгалын сангийн урсгал төсвийн санхүүжилтээс ТЕЗ-ийн шийдвэргүйгээр суудлын авто машин 20.0 сая төгрөгөөр худалдан авч “Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан төсвийн шууд захирагч, түүний бүрэн эрх, мөн хуулийн 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн.

#### 1.2. Өгсөн шаардлага:

Тайлант онд эрүүл мэндийн даатгалын сангийн урсгал төсвийн санхүүжилтээс ТЕЗ-ийн шийдвэргүйгээр суудлын авто машин 20.0 сая төгрөгөөр худалдан авсан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 25-ны дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар ирүүлэх байна.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Улсын бүртгэлийн гэрчилгээ дээр сумын статустайгаар үйл ажиллагаагаа явуулж байгаа нь Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т “хуулийн этгээдийн мэдээлэлд орсон өөрчлөлт” оруулах, Хууль зүй, дотоод хэргийн сайдын ХЗДХС-ын 2021 оны А/278 дугаар тушаалын 7 дугаар зүйлийн 7.1-т хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрыг тухайн хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагаа явуулах нутаг дэвсгэрийг харьяалах улсын бүртгэлийн байгууллагад бүртгэнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

#### 1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

#### 1.3. Илрүүлэлт:

Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын хүн эмнэлэг нэртэйгээр Улсын бүртгэлийн гэрчилгээ дээр үйл ажиллагаагаа явуулж байгаа нь Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т “хуулийн этгээдийн мэдээлэлд орсон өөрчлөлт” оруулах, Хууль зүй, дотоод хэргийн сайдын ХЗДХС-ын 2021 оны А/278 дугаар тушаалын 7 дугаар зүйлийн 7.1-т хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрыг тухайн хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагаа явуулах нутаг дэвсгэрийг харьяалах улсын бүртгэлийн байгууллагад бүртгэнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

**1.4. Өгсөн зөвлөмж:**

Улсын бүртгэлийн гэрчилгээ дээрх сум/тосгоны нэрийг тодорхой болгож Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т “хуулийн этгээдийн мэдээлэлд орсон өөрчлөлт”-ийг хэрэгжүүлж ажиллах.

**2. Илрүүлэлт:**

Шилэн дансанд байршуулах мэдээлэлд аудитын тайланг хугацаа хоцроож байршуулсан нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

**2.1. Өгсөн зөвлөмж:**

Шилэн дансны тухай хуулийн 6-р зүйлийн 6.1 хэсэгт заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн гүйцэт мэдээлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Эрдэнэбулган сумын эрүүл мэндийн төв	2	20.7	1	0.7	-	-	1	20.0	1	0.7